



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/389

Чингис хот

Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.17 дахь заалтын хүрээнд "Эрүүл мэнд хөдөлгөөн-Хөгжил" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улаанбаатар хотын СИТИМЕД эмнэлэгтэй хамтран Баянхутаг, Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумын иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад 14817000 /арван дөрвөн сая найман зуун арван долоон мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баасандорж/-д үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх үзлэгт зарцуулагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

Зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Томилолт	12000	8	576.000
2	Хэвлэл	60000	3 ш хөлтэй самбар	180.000
3	Баннер	15000	4 м ²	350.000
4	Гарын авлага	2500	1000 ш	250.000
5	Гар ариутгагч, маск, нэг удаагийн бээлий	2500 200 1200	Хоногийн хэрэглээгээр тооцоолов	220.000
6	Шатахууны зардал	2100	1500 км*4 машин	1.807.930
7	Эмч нарын үзлэг	5000	700	3.500.000
8	Шинжилгээ	5000	700	3.500.000
9	Шүдний ломбоны материал	25000	4	100.000
10	Үзлэгийн толь	3000	200	600.000
11	Сүрьеэгийн рентгений халь	1163	400	465.200
Урвалж бодис				
12	Бруцеллёз /роз бенгал, bruc abor, bruc meli/	100 х/т -68.000	300 х/тун	196000
	Тэмбүүгийн оношлуур /TRNA/	200 х/т -220000	400 х/тун	440000
	Тэмбүүгийн оношлуур /RPR/	500 х/т *200000	2000 х/тун	400000
	ДОХ-ын оношлуур	1 х/тун *1600	300 хүн тун	480000
	Хуруу шил /зүүний хамт/	1 хос багц *230	2000 х/тун	460000
	Бээлий	1 хос *200	800 хос	160000
	Үзлэгийн толь	1 ш *550	400 ш	220000
	Граммын будаг	1 ш -82000	1 ш	82000
	Шар хошуу	1000 ш -25000	3000 ш	100000
	Бамбар	150 ш *30000	300 ш	60000
	Хеликобактери	1*25ш-2000	100тест	200000
	Шээсний туузан оношлуур	100тест-35000	300тест	105000
	Үе мөчний оношлуур /АСЛО, Rev/ Factor, C reactive protein/	100ш*1цомог 198000	2цомог	358000
	Тавиур шил	1*50-3500	2хайрцаг	7000
Нийт дүн				14.817.000